

ЭДИЙН ЗАСГИЙН ГЛОБАЛЧЛАЛ: АНУ-ЫН ХӨГЖЛИЙН ТУСЛАМЖ

*Ц.Баатар**

Эдийн засгийн глобалчлалын өнөөгийн эринийг судлаачид “шинэ эдийн засгийн эрин”, “шинэ капитализмын эрин”, “шинэ либерализмын эрин” гэх мэтээр янз бүрээр томъёолон эдийн засгийн хэвшсэн үзэл баримтлалуудад шүүмжлэлтэй хандах болов. Энэ үүднээс хөгжлийн асуудлуудад хандах хандлага ч урьд өмнөхөөсөө өөрчлөгдлөө. Өөрчлөлтийн эхлэлийг чухамдаа АНУ тавилаа.

Глобалчлалын үр шимийг хамгийн их хүртэж буй орны нэг хэмээгддэг АНУ хэдийгээр эдийн засгийн нь өсөлт базаахгүй, дээр нь улс орноо хамгаалах, терроризмын эсрэг тэмцэх гээд хэдэн зуун тэрбумын зардал гарч буйг ч үл анзааран хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт, хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж, хөгжингүй улс орнуудыг уриалсан зарчмын хувьд асар их ач холбогдолтой, энэ чиглэлийн бодлогын хөгжилд хувьсал болохуйц цоо шинэ санал дэвшүүлсэн билээ. Энэхүү санал санаачлагын тухай ярихын өмнө ер нь дэлхийн эдийн засгийн хөгжлийн луужин болсон энэ орон өөрөө хүчирхэгжин өсөн өндийхийн хэрээр бусад улс орныг араасаа дагуулахын тулд байнга санаа тавьж тусламжийн гараа харамгүй сунгаж ирсэн түүхийн хуудсыг сөхөж үзэх нь зүйд нийцэх бизээ.

Америкийн түүхэнд Ерөнхийлөгч нь аюул тохиолдсон үед гурван удаа ард түмэндээ хандаж, гадаад тусламжийн асуудлаар томоохон үг хэлсэн байдаг. Анхных нь Гарри Трумэн. Тэрбээр одоогоос 56 жилийн өмнө буюу хүйтэн дайн эхлэж байсан 1947 оны гуравдугаар сарын 12-нд Конгрессын хамтарсан чуулган дээр үг хэлж, Грек болон Туркт нойтой аюул нүүрлээд байгааг сэрэмжлүүлж байв. Түүнээс гурван сарын дараа Төрийн нарийн бичгийн дарга Жорж Маршалл Харвардын их сургуульд зочлох үеэрээ хэлсэн алдарт үгэндээ, Америк Европын улс орнуудын эдийн засгийн хэвийн эрүүл саруул байдлыг сэргээхэд тусламж үзүүлэх болсоноо зарласан билээ.

Түүхнээ “Маршаллын төлөвлөгөө” хэмээн мөнхөрөн үлдсэн энэхүү суут төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Европ тивийг өлсгөлөн, ядуурал, эмх замбараагүй байдлаас ангижруулсан билээ. Үүний сацуу энэхүү төлөвлөгөө Европчууд хүчээ хамтатган, өөрсдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, өөрсдийгөө өөд нь татах программ

*Ц.Баатар – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

боловсруулан хэрэгжүүлэх гол хөшүүргийн үүрэг гүйцэтгэсэн. Маршаллын төлөвлөгөөний дагуу АНУ-ын үзүүлсэн асар их тусламж дэмжлэг нь Европын интеграцчлалын үйл явцыг эхлүүлж, өдгөө бидний сайн мэдэх цэцэглэн хөгжсөн, ардчилсан, тогтвортой Европ тивийн улс төр, эдийн засгийн үндэс суурийг тавьсан билээ.

Олон улсын хөгжлийн асуудлаар чухал санаачлага гаргаж ард түмэндээ хандсан хоёрдахь Ерөнхийлөгч бол Жон Ф.Кеннеди байлаа. Хүйтэн дайн ид ширүүсч байсан 1961 оны гуравдугаар сарын 13-нд тэрбээр Дэвшлийн төлөө холбоо байгуулснаа зарласан бөгөөд энэ нь Латин Америкийн ард түмний гол гол эрэлт хэрэгцээг хангах 10 жилийн хугацаатай төлөвлөгөө байсан юм. Есөн өдрийн дараа Кеннеди Конгресст илгээлт явуулснаар одоогийн бидний сайн мэдэх АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлаг /ОУХА/ байгуулагджээ.

Гадаад тусламжийн асуудлаар томоохон мэдэгдэл хийж, ийнхүү тусламж үзүүлэх нь АНУ-ын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын эрх ашигт чухал хэмээн үзсэн гуравдахь хүн бол одоогийн Ерөнхийлөгч Буш юм.

Ерөнхийлөгч Буш 2002 оны гуравдугаар сарын 14-нд Америк дундын хөгжлийн Банкинд хандан үг хэлж, 5 тэрбум доллар бүхий Мянганы Зорилтын Данс /МЗД/ нээснээ дэлхий нийтэд зарлалаа. Энэ бол гадаад тусламжийн хэмжээг урьд өмнө байгаагүй ихээр нэмэгдүүлсэн хэрэг юм.

Буш “Баян, ядуу, гачигдал хоёрын хоорондох ялгаа ихсэж, аль алин нь тогтворгүй байдлын шалтгаан болж, бидний санаа сэтгэлийг зовинуулж байна. Бид аллага хядлагатай ч, бас амьдралыг утга учиртай болгож буй үнэ цэнэтэй зүйлсийн төлөө ч, боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн боломжийн төлөө тэмцэх ёстой” гээд Гэхдээ энэхүү тусламжийн санг “авилгалыг устгаж, хүний эрхийг хүндэтгэн, хууль ёсыг удирдлага болгохын сацуу нээлттэй зах зээл, төсвийн тогтвортой бодлого явуулдаг” тийм улс орнуудад зориулна гэдгээ тов тодорхой мэдэгдлээ.

Эдгээр асуудлыг Ерөнхийлөгч Буш онцлон авч үзэхдээ, бодит тодорхой онол, практикт тулгуурласан гадаад тусламжийн цоо шинэ бодлого боловсруулан, АНУ-ын гадаад тусламжийн программыг цаашид улам үр нөлөөтэй болгохоо ч мэдэгдэв.

Гэтэл нөгөө талд тусламж хүртэгч орнууд түүнд хэрхэн хандаж ирсэнийг цухас авч үзье.

Хөгжиж байгаа орнууд АНУ-ын хийгээд олон улсын байгууллагын хөгжлийн тусламжийн талаархи ойлголт харилцан

адилгүй. Ихэнхи хөгжиж байгаа орнуудын эрх баригчид өөрсдийн арчаагүй байдлаа хамгаалах бамбай болгож хөгжлийн асуудлаар өөрсдөд нь таалагдаагүй үзэл санааг няцаахад зориулан янз бүрийн үзэл, номлол гаргаж түүнийгээ хэрхэн ашиглаж чадаж байгааг бид мэдэх билээ. Тэдний дунд түгээмэл дэлгэрсэн онолын нэг бол Ихамаарлын гэгч онол юм. Энэ онолоор хөгжиж байгаа орнууд ядуу байгаа нь баялагыг олж авахын тулд эдийн засаг, улс төрийн давуу талуудаа ашиглаж байгаа чинээлэг улс орнуудын хомхой сувдаг хандлагын золиос болж байгаагаас үүдэлтэй гэнэ.

Зарим нэг хөгжиж байгаа орны удирдагчид эдийн засгийн тааруухан бодлого явуулж, базаахгүй засаглаж байгаагийнхаа төлөө хүлээх хариуцлагаас мултрах гэхдээ дээр өгүүлсэн хамаарлын онолыг эдүгээ болтол ашигласаар ирэв. Тэдний үзэж буйгаар, аль нэгэн орны удирдлага улс орноо зөв залж чиглүүлээд аваад явж чадахгүй байгаа бол түүний төлөө нөгөө нэг улс орон заавал хариуцлага хүлээх ёстой гэнэ. Хөгжингүй болон шинээр үйлдвэржсэн, зах зээлийн орнуудын удирдагчдын мэдэгдлийг анхааралтай авч үзвэл, тэдний хэлж ярьж байгаа зүйлээс хамаарлын онолыг бид олж харахгүй.

Хоёр дахь улиг домог нь эхнийхээс үүдэлтэй бөгөөд Өрнөдийн баян чинээлэг орнуудын орлогыг Өмнөдийн ядуу буурай орнуудад дахин хуваарлавал дэлхий дахинд ядуурлын асуудлыг шийдэх боломжтой гэж үздэг. Сэтгэлгээний ийм сургуулийн үндэслэл нь дэлхийд баялагын хэмжээ хязгаартай гэдэгт үндэслэдэг. Гэвч баялаг гэдэг бол яс тогтоосон зүйл биш. Баялагын нийт хэмжээ нь эдийн засгийн хөшүүрэг, түүнчлэн баян юмуу ядуу ч бай, эсвэл Өрнөдийн юмуу Өмнөдийн ч бай хамаагүй аль ч улс орны сонгож авсан засаглалын тогтолцооноос хамааран нэмэгдэх юмуу багасч болно.

Гуравдахь улиг домог нь хөрөнгө бол хөгжлийн хөдөлгүүр мөн гэж үзэх явдал мөн. Энэ бол ерөөс огт буруу ойлголт. Бодит байдал дээр бол эдийн засгийн тодорхой бодлого болон засаглалын тогтолцоо маш чухал зүйл. Эрсдэл агуулдаг нийгмийн үнэт зүйлс, шинэ үйлдвэр, ажлын шинэ шинэ байр бий болгоход нөлөөлдөг таатай уур амьсгал, үйлдвэр худалдаа эрхлэх боломж олгодог сургалт боловсролын тухай асуудлыг саяхан болтол хангалттай өргөн хүрээнд авч үздэггүй байлаа. Эдгээр нь илүү их ач холбогдол өгч анхаарал хандуулвал зохих эдийн засгийн өсөлтийн макро эдийн засгийн чухал асуудлууд юм.

Хөгжлийн албан ёсны тусламж нь АНУ юмуу эсвэл Өрнөдийн улс орны засгийн газрын чухам алинаас нь үзүүлж байгаагаас үл

хамааран хөгжиж байгаа ертөнцийг аль болох богино хугацаанд хөгжил дэвшилд хүргэх зорилго агуулдаг. Тийм учраас хөгжиж буй орны удирдлагаас улс орондоо эдийн засгийн ухаалаг бодлого явуулж, засаглалын шударга тогтолцоо бүрдүүлэн бэхжүүлэхийг тэдэнд зөвлөмж болгодог.

Хөрөнгө нээлттэй эдийн засаг, ил тод хууль эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудад л цутган орж ирдэг.

Эцэст нь дөрөвдөх амь бөхтэй улиг домог бол АНУ болон Өрнөдийн ардчилсан улс орнууд бусдаас ямар нэг байдлаар илүү байдаг учраас л баян чинээлэг болсон хэмээх үг яриа юм. Энэ бол бас л эндүүрэл. Хүн гэдэг бол уг мөн чанараараа ерөөс унхиагүй амьтан. Энэхүү сул талыг үл тоомсорлосон улс төрийн байгууллаууд бүтэлгүйтсээр ирснийг “халамжлагч” социалист системийн тогтолцооноос бид сайн мэдэх болсон билээ. Шинэ либерализм аливаа үндэстний соёл, уламжлалын янз бүрийн хэлбэрт зохицон, хөгжлийн тэргүүлэх хэв загвар болсон хэвээр байна. Ардчилсан капитализм хүний мөн чанарын аугаа их сүр хүч болон сул талуудыг аль алийг нь хүлээн зөвшөөрч, сул талыг нь хязгаарлан, сүр хүчийг нь урамшуулан дэмждэг улс төрийн тийм байгууллауудыг бий болгодог.

Эдийн засгийн шинэчлэлд учирч буй саад тотгорыг арилгах, улс төрийн тогтолцоон дахь авилгалыг таслан зогсоох, захиргааны менежментийг илүү хариуцлагатай бөгөөд ил тод болгохын тулд шилжилтийн өөрчлөлтийг үндэсний удирдлага орон нутгийн дэмжлэгтэйгээр хийх ёстой. Ийм удирдлага бий болж, ажиллахад юу нөлөөлж болох вэ гэдэг нь бидний хувьд ихэд сонирхон авч үзүүштэй асуудал мөн. Үүнд өгөх хариултын нэг хэсэг нь олон улсын тусламжийн байгууллагууд дахь хөшүүргийн мөн чанарт ч байж болох юм.

Хөгжиж буй ертөнцөөс үүдсэн сургамжууд

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагаас явуулж буй бодлогоос харж байхад АНУ болон хөгжингүй орнууд хөгжлийн өнөөгийн өндөрлөгт хүрэхийн тулд туулж өнгөрүүлсэн олон зууныг хөгжиж буй орнууд аль болох богино хугацаанд туулахад тусламж үндсэндээ чиглэж байна.

Хөгжлийн тусламж нь тусламж авч буй тухайн орны ухаалаг, зөв мэргэн бодлоготой зохистой хосолж чадсан нөхцөлд хөгжингүй орнуудын туулсан хөгжлийн замыг асар богино хугацаанд туулж болохыг

Монголчууд бидний хошуурах болсон Өмнөд Солонгосын туршлага харуулсан билээ.

Судлаачид Солонгосын дайнаас хойшхи тус улсын хөгжлийн 22 жилийн түүхийг судалж үзээд гадаадын тусламж эхний арав гаруй жилийн хөгжилд нь чухал хүчин зүйл болсныг олж тогтоосон байна. Гэвч 1950-иад оны сүүлчээр солонгосчууд эдийн засгаа хөгжүүлэх талаар өөрсдөө маш чухал цуврал арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Тэд инфляцыг бууруулан, төсвийн алдагдлыг багасгаж, эдийн засгаа чөлөөтэй болгохын сацуу экспортыг дэмжсэн байна.

1960-оны дунд үе гэхэд зээлийн хүүгээр дотоодын хадгаламжийг маш өндөр хэмжээнд буюу 1969 он гэхэд 21,7 хувьд хүргэсэн нь АНУ болон Өрнөд Европт үзэгдэж дуулдаагүй үзүүлэлт байв. Мөн онд улс орны экспортын тодорхой бодлогоор дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэг жилд 15 хувиар өсгөсөн нь нийт арав гаруй жилийн хугацаанд дундажаар 8 хувь байсан билээ.

1993 онд Дэлхийн Банкнаас хэвлүүлсэн “Зүүн Азийн гайхамшиг” хэмээх номонд Япон улсын зэрэг Азийн дөрвөн “Бар” 1965-аас 1990 оны хооронд дэлхийн бусад улс орныг бсдвол илүү хурдацтай хөгжиж, бодит орлого нь дөрөв гаруй дахин буюу 400 хувиар өсчээ хэмээн цохон тэмдэглэсэн байдаг.

Дэлхийн банкны судалгаанд: “Дотоодын хувийн хөрөнгө оруулалт, түргэн өсч буй хүний нөөц хоёр өсөлтийн гол хөдөлгөгч хүч нь байлаа. Дотоодын санхүүгийн хуримтлал өндөр байсан нь хөрөнгө оруулалтыг мөн өндөр хэмжээнд тогтвортой байлгаж байв. Хөдөө аж ахуйн салбар харьцангуй нөлөө багатай байсан хэдий ч бүтээмжийнх нь өсөлт хурдацтай дээшилжээ. Өндөр үзүүлэлттэй Азийн эдгээр улсад хүн амынх нь өсөлт дэлхийн хөгжиж байгаа бусад хэсгийнхээс илүү хурдан хугацаанд буурсан байна” гэж дурджээ.

Энэхүү илтгэлд хөрөнгө оруулалтын маш тааламжтай орчин бүрдүүлдэг макро эдийн засгийн хүчтэй менежмент, ажиллах хүчний чадварыг хурдан хугацаанд дээшлүүлэх бололцоо олгодог бага, дунд боловсролын давуу талуудыг онцлон дурдсан байдаг. Энэ мэт эдийн засгийн өсөлт хөгжилд нөлөөлдөг чухал хүчин зүйлсийг энэ чиглэлийн судалгааны бүтээлүүдээс хэдэн арваар нь эш татаж болох юм.

Америкийн эрдэмтэн Билл Истерли саяхан хэвлүүлсэн “Өсөлт хөгжлийн цөхрөлтгүй эрэлд” гэдэг номондоо өсөлт, хөгжлийн асуудалд хандах хандлагуудыг шүүмжилсэн олон янзын үнэлэлт дүгнэлтүүдийг хийсэн байна. Тэрбээр өсөлтөд зайлшгүй хүргэдэг “шидэт рашаан” гэгч

байдаггүйг дурдаад, анхаарлаа анхдагч эхлэлүүдэд хандуулсан байна. “Хэрэв нэгдэх ертөнцийн хандивлагчид, гуравдахь ертөнцийн засгийн газрууд, мөн гуравдахь ертөнцийн эгэл жирийн ард иргэд энэ гурав зөв эхлэлтэй байх аваас хөгжил дэвшилд хүрнэ. Эс тэгвээс юунд ч хүрэхгүй” гэж тэр бичжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Бушийн МЗД чухамдаа дээрхи 3 эхлэлийг зөв тавихад үндсэндээ чиглэж байна гэж үзэж болох юм. МЗД-аас тусламж авах болзол хангасан хөгжиж буй орнуудын хувьд дан ганц амлалт биш, ажил хэргийн чанарыг эрхэмлэх шинэ чиглэлийг тогтоож өглөө. Үүнтэй холбогдуулан АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн захиргааны дарга Эндрю Нациос Мянганы Зорилтын Дансны бүтцийн зорилтыг тодорхойлж “хөгжиж байгаа орнууд дахь шинэчлэлтийн талынхныг шилжилтийн үеийн өөрчилөлтүүдэд дургүйцэгчдийн эсрэг хэрэглэх хүчирхэг хэрэгсэлтэй болгох замаар хөгжил дэвшлийн үйл явцыг хурдасгах урамшууллын тогтолцоог бүрдүүлэхэд оршино” гэжээ. Мянганы Зорилтын Данснаас хөгжиж буй оронд үзүүлэх тусламжийн хэмжээ АНУ-ын засгийн газраас одоо олгож байгаагаас даруй 5-10 дахин их байх аж.

Ерөнхийлөгч Буш 2002 оны гуравдугаар сарын 14-нд хэлсэн үгэндээ ямар болзол хангасан улсад шинэ Мянганы Зорилтын Данснаас тусламж үзүүлж болохыг тодорхойлохдоо дан ганц амлалт биш, ажил хэргийн чанарыг эрхэмлэх шинэ чиглэлийг тогтоосон юм. МЗД-аас тусламж авах болзолыг хангасан байх гурван шалгуурыг Ерөнхийлөгч Буш санал болгож байгаа юм.

МЗД-ны нэгдэх шалгуурт эдийн засгийн чөлөөт байдал, хувийн хөрөнгө оруулалт, үйлдвэр худалдаа эрхлэлтийг дэмжсэн бодлого баримтлах асуудал орж байна. Үүнтэй холбогдуулан дурьдахад хөгжиж байгаа өдий төдий улс орон дэлхий дахины шинэ эдийн засгийн боломжтой давуу талуудыг хэрхэн ашиглах асуудалд тэр бүр анхаарахгүй байна. Үүнээс болж асар их боломж алдаж байна. Жишээ нь: Дэлхийн буурай хөгжилтэй 49 улсад дэлхийн худалдааны 1 хувийн тэн хагасаас бага хувь нь ногдож байна. Энэ бол эдийн засгийн өсөлтийг хангах арга зам биш ээ.

Тийм учраас МЗД-ны хүрээнд хөгжиж байгаа орны эдийн засгийг түргэн хурдацтай хөгжүүлэхэд хамгийн чухал хүчин зүйлийн нэг болсон макроэдийн засгийн шинэчлэлтийн асуудалд онцгой анхаарал тавьж байгаа юм.

Мянганы Зорилтын Данстай холбоотойгоор Ерөнхийлөгч Бушийн тогтоосон хоёрдахь шалгуур нь эдийн засгийн өсөлт, хөгжилд зохистой засаглал гол чухал нөлөөтэй хэмээн үзэж буй явдал мөн.

Үүнийг Ерөнхийлөгч “зөв шударгаар удирдах явдал” гэж нэрлэсэн байна. Энэ чиглэлээр АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг сүүлийн 10-15 жилийн хугацаанд их зүйл хийснийг бид мэдэх билээ. Тухайлбал, ардчилсан байгууллуудын хөгжилд дэмжлэг үзүүлэхэд ихээхэн санаа тавьж, Ардчилалын төлөө Хандив, Олон улсын бүгд найрамдахчуудын хүрээлэн, Үндэсний ардчилсан хүрээлэн зэрэг Төрийн бус ардчилсан байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

АНУ-ын ОУХА-ын зүгээс хөгжиж буй ертөнцөд хамгийн ноцтой уршигт үр дагавар тарьж буй авилгатай тэмцэх асуудалд ихээхэн тусламж дэмжлэг үзүүлдэг. Тийм ч учраас хөгжлийн агентлаг хөтөлбөрүүддээ үүрэг хариуцлага, хууль ёсыг удирдлага болгох, авилгалыг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх талаар онцлон анхаарч байдаг.

Мянганы Зорилтын Данстай холбоотойгоор Ерөнхийлөгч Бушийн тогтоосон гуравдахь шалгуур нь хөгжиж байгаа улс орнууд эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулж, үйлчилгээний үр нөлөөг сайжруулах талаар бодит тодорхой үүрэг хүлээдэг байх асуудал орж байна. Эдийн засгийн өсөлт нь тогтвортой өндөр хэмжээнд байгаа улс орнууд ард түмнийхээ эрүүл мэнд, боловсролын талын үйлчилгээнд байнга хөрөнгө оруулж, тэгснээрээ өсөн нэмэгдэж байгаа эдийн засгийн салбарт ажиллах хүчин бий болгоход тус дөхөм үзүүлдэг. Нийгмийн үйлчилгээний энэхүү хоёр салбарт хөгжлийн тусламж үзүүлснээр сүүлийн хэдэн жилд асар их ахиц дэвшил гарчээ. Анхан шатны боловсролын давуу талууд нь бусад салбарт томоохон түлхэц болж байдгийг бид мэднэ.

АНУ-ын ОУХА-т Дэлхий Дахины Хөгжлийн Холбоог байгуулсан бөгөөд энэ нь хөгжиж буй ертөнцөд орж буй хувийн капиталын урсгалыг улсынхтай хослуулах гэсэн оролдлого юм. 30-40 жилийн өмнө АНУ-аас Гуравдахь ертөнцөд оруулж байсан хөрөнгийн урсгалын 70 хувь нь албан ёсны хөгжлийн тусламж, 30 хувь нь хувийн капитал байсан бол одоо огт эсрэг болж, хөгжиж байгаа ертөнцөд оруулж байгаа капиталын урсгалын 80 хувь нь хувийн капитал, дөнгөж 20 хувь нь албан ёсны хөгжлийн тусламж эзэлж байна.

Үүнийг албан ёсны хөгжлийн тусламж үнэмлэхүй хэмжээгээрээ буурсан гэсэн үг биш. Харин хувийн болон ашгийн бус салбарынхан

хөгжиж буй ертөнцөд оруулах хөрөнгийнхээ хэмжээг асар их нэмэгдүүлсэн гэсэн үг юм. Энэ нь бизнес эрхлэгчдээс оруулж буй дан ганц хувийн хөрөнгө ч бас биш. АНУ-аас хөгжиж буй ертөнцөд орж байгаа ашгийн бус капиталын нийт урсгал жилд 4 тэрбум доллар болж байгаа нь Албан ёсны хөгжлийн тусламжаас даруй дөрөв дахин их байна. Ингэхлээр Албан ёсны хөгжлийн тусламжтай зүйрлэхээргүй их хэмжээний бичил санхүүжилт хөгжиж байгаа орнуудад орж байна гэсэн үг.

Хувийн салбараас орж буй капиталын урсгалыг эрчимжүүлэх ажлыг хөгжлийн тусламжтай хэрхэн яаж уялдуулан зохицуулвал зохистой вэ? гэсэн чухал асуулт гарч байна. Янз бүрийн сангаас хөгжиж буй орнуудад жил бүр асар их хэмжээний хөрөнгө мөнгө илгээж байна. Түүнийг хөгжил дэвшлийн хөшүүрэг болохуйц зүйлд үр ашигтай зарцуулах асуудал маш чухал.

Монгол улсын хувьд өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хандивлагчид хийгээд олон улсын байгууллага, улс орон, янз бүрийн сангаас чамлахааргүй тусламж дэмжлэг авсан.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг/ОУХА/ Монгол улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хэд хэдэн чиглэлээр тусламж дэмжлэг үзүүлж байна. 1990-2000 онд эрчим хүчний салбарт техникийн шинэчлэлт хийх, эдийн засгийн макро түвшинг тогтворжуулах, ардчилалыг бэхжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах гэсэн 4 үндсэн чиглэлээр нийтдээ 130 орчим сая долларын буцалтгүй тусламж үзүүллээ. ОУХА Монголд үзүүлэх тусламжаа эхэн үедээ гал унтраахад зориулж байсан бол сүүлийн үед урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжин урамшуулахад чиглэх болов. Ардчиллыг дэмжин хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлт хөгжлийг урамшуулан дэмжихэд зориулан олгож буй тусламж нь шүүх засаглалын шинэтгэлийг эрчимжүүлэх, ардчиллын үйл явцыг гүнзгийрүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангахад үндсэндээ чиглэж байна. Дээрхи чиглэлүүдээр олон төсөл хэрэгжиж байна.

АНУ-ын ОУХА дамжуулан олгож байгаа тусламжийг Монголын тал зориулалтаар нь ашиглаж, үр дүнд хүрч байна уу гэдэг асуулт тавигдах нь мэдээж. Манайх энэ тал дээр тун маруухан. Өгсөн тусламжийн улаанбуудайг нь үрэн таран хийж зувчуулсан, түүний хойноос Элчин сайд нь шүүхдэж явах жишээтэй. Иймэрхүү нүүр улайлгаж, нүд бүлтийлгэж, чих дэлдийлгэсэн хачирхалтай зүйлсийг

ганцхан Америкийн ч бус алив зээл, тусламжийг ашиглаж буй Монголын нийтлэг төрх гэж болно.

Гаднаас орж ирсэн зээл тусламж, хандив төслийн хөрөнгийг хулгайлж завшдаг яам, агентлагийн ажилтан, аж ахуй, банкныхан оролцсон гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэглэл бий болсонтой энэ бүхэн холбоотой. Түүгээр ч үл барам авилгал газар авч яамдын сайд, төрийн түшээд холбогдсон тухай материалууд төвийн хэвлэлд тогтмол нийтлэгдэх болов. Үүнд нь гадныхан хүртэл санаа зовж хэвлэлд авилгал авсан байж болзошгүй төрийн түшээдээс 2 нь авилгал авсаныг би мэднэ гэж АНУ-ын элчин сайд Жон Дингер саяхан мэдэгдлээ. Энэ бүхэн монголчуудын муу муухайг үзэх гэсэндээ биш архагшин буглаж буй хорт зуршлаасаа ангижирч хөгжил дэвшилд хурдан хүрээсэй гэсэн сайн санааны нэгэн илрэл гэлтэй. Тэр нь ч олон зүйлээр илэрч байдаг. Энэ оны эхээр АНУ-д тусламжийн чиглэлээр болсон уулзалт ярилцлагад Ж.Дингер оролцож Мянганы зорилтын данснаас тусламж авах хамгийн өндөр магадлалтай орны нэг бол Монгол улс гэж мэдэгдээд хөгжил дэвшилд нь зориулан олгож буй тусламж дэмжлэгийнхээ хэмжээг нэмэгдүүлэхийг уриалав. Тусламж хариуцсан хүмүүсийг ч урьж ирүүлэн бодит байдлыг нь ойлгуулах гэж монголчууд биднээс илүү хичээн зүтгэж явна. Энэ бүхэн нь ардчиллыг тууштай сонгосон, Азийн буурай жижиг Монгол улсын залуу үеийнхэнд төлөө хийж буй буянт үйлс гэхээс аргагүй. Манай залуу үеийнхэн АНУ-ын тусламжаар бус глобалчлалын эриний соёл иргэншлийн чиг хандлагыг соргоогоор мэдэрч, хэний ч шахалт шаардлагагүйгээр Америкийн соёл иргэншлийг хүлээн авч, асар их хурдаар америкжиж буйг онцгойлон анхаарч буйн нэгэн илрэл гэж үзвэл зүйд нийцэх биз ээ. Тэрнээс биш ноён элчин сайдын хэлсэнчлэн шүүмжлэл хүлээн авахаа байсан “зузаан арьстан”-гуудад зориулаагүй нь тодорхой. Хэрэв сайн санаат хүмүүсийн ач тусаар тэр МЗД-аас Монгол улс хувь хүртэх завшаан тохиодог бол тэрнийг бүгдийг нь Баабарын мөрөөдлийг биелүүлж 30000 залуусаа Америкт боловсрол олж авахад нь зориулахсан Ингэвээс Монголын хувьд өсөн өндийх хөгжлийн нэгэн тулах цэгээ олж буй нь тэр.

Ашигласан эх сурвалж

1. U.S. Foreign Policy Agenda, Volume 7, №3, November, 2002
2. U.S. Foreign Policy Agenda, U.S. National Security a New Era, Volume 7, №4, December, 2002
3. Bulletin, October 25, 2002, U.S. Embassy Ulaanbaatar Mongolia,
4. Bill Easterly. The Elusive Quest for Growth, 2002